

■ ХҮНИЙ ЭРХ

Эрх нь зөрчигдсөн иргэдийг хамтран ажиллахыг уриаллаа

Идэрнастын Алтангэрэл
сурвалжлагч

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2006 онд Хүний эрхийн зөвлөлийг байгуулан, гишүүн 192 улсын хүний эрхийн төлөв байдлыг дөрвөн жил тутамд хэлэлцэж байхаар болсон. Үүнтэй холбогдуулан «Хүний эрх хөгжил төв» болон «Глоб интернэшнл» ТББ-ууд мэдээлэл хийсэн юм.

Монгол Улсын Засгийн газар энэ жил анх удаа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн есдүгээр хуралдаанд оролцож, хүний эрхийг хангах, хамгаалах талаар олон улсын болон иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа хэрхэн хэрэгжүүлж байгааг Швейцарийн Женев хотноо энэ оны 11 дүгээр сарын 23-ны өдөр болох хэлэлцүүлэгт илтгэж тайлагнах юм. Үүнээс гадна уг хуралдаанд манай улсад НҮБ-ыг төлөөлөн суугаа төрөлжсөн байгууллагууд, Хүний эрхийн үндэсний комисс, хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд оролцох боломжийг бүрдүүлжээ.

Иймээс Хүний эрхийн хөгжлийн төлөөх «Азийн форум» байгууллагын дэмжлэгтэйгээр «Хүний эрх, хөгжил төв» болон «Глоб интернэшнл» ТББ хамтран энэ сарын 10-12-ны өдрүүдэд хүний эрхийн талаарх дүгнэлт

хэлэлцүүлгийг хийсэн юм.

Тус хэлэлцүүлэгт манай улсад хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй ТББ-ууд оролцож, Монгол Улс дахь хүний эрхийн жинхэнэ төлөв байдлыг бодитоор харуулсан илтгэл тайланг бэлтгэн, Засгийн газрын илтгэл тайлангаас өмнө хүргүүлэхээр болсон байна.

Манайд үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөгөө эдэлж чадахгүй байгаа тохиолдол олон гарах болсон. Тухайлбал хүнснийхээ хэрэгцээг бүрэн хангах чадамж дутмаг, бараа бүтээгдэхүүнийхээ ихэнх хувийг гадаадаас авч байгаа, нийслэлийн агаарын бохирдол зэргээс болж бидний эрх зөрчигдсөөр байгааг тэд дурдсан юм.

Тиймээс ТББ-ууд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлэх илтгэлдээ 2008 оны долдугаар сарын нэгний үйл явдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн талаар болон байгаль орчин, уул уурхай, хүнсний эрх, цөөнхийн эрхийн байдал, шилжин суурьшигчдын хүний эрхийн байдал, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаар тус тус илтгэл бэлтгэн оролцохоор болжээ. Хүний эрхийн асуудалд санаа зовнин ажилладаг ТББ болон иргэдийг ээлжит хэлэлцүүлэгт бэлтгэх ажилд идэвхтэй оролцож, хамтран ажиллахыг уриаллаа.